

Бичиг

баримтгүй

цагаач

хүүхдүүд

сургуульд

явах

эрхтэй!

Шведэд байгаа 6–18 настай бүх хүүхдүүд боловсролтой болох эохтэй, үүнд бичиг баримтгүй цагаачын хүүхдүүд ч багтана. Энэ нь урьдчилсан сургууль, бага, дунд болон тусгай боловсрол болон сургуулийн унаанд хамаарна.



Бүх хүүхдүүдэд зориулсан

сургууль!

Сайн уу!

2013 оны 7 сарын 1 нээс, Шведэд байгаа бүх бичиг баримтгүй цагаачдын хүүхдүүд, хуулийн дагуу, бусад хүүхдийн адил эрхтэй болсныг та мэдсэн үү? Энэ нь бүх хүүхдэд дараах эрх байгаа:

- Урьдчилсан-сургууль - Хүүхэд 6 нас хүрэх үед, тэр зургаан-настны сургалт эхлүүлэх боломжтой. Энэ нь хүүхдийг бага сургуульд бэлддэг. Ном болон өдрийн хоол үнэгүй.
- Дунд сургууль - Хүүхэд 7 нас хүрэхэд, тэр бага сургууль явах боломжтой. Хүүхдүүд үнэгүй ном ба өдрийн хоол авдаг. Бага сургууль нь 9 жил байдаг.

Ахлах сургууль - Дунд сургууль төгссөн хүүхдүүд ахлах сургуульд явахаар сонгож болдог. Маш олон төрлийн ахлах сургуулийн хөтөлбөр байдаг ба, голцуу 3 жилийн хугацаатай байдаг. Хэрэв та, бичиг баримтын цагаачын хувьд, 18 наснаас өмнө ахлах сургуульд орох ба, та 18 наснаас хойш ч ахлах сургуульд сурах боломжтой.

Тусгай боловсрол - Тусгай боловсролын сургууль нь тахир дутуу хүүхдүүд болон залуу хүмүүс боловсрол эзэмших боломжтой юм.

Хэрэв шаардлагатай бол сургуульд хүргэж өгөх болон авах боломжтой. Хэрэв та өөрийн байгаа хаягийг мэдэгдэхийг хүсэхгүй байгаа бол авах хаяг өгөх эрхтэй.

Мөн түүнчлэн Шведэд, сургуулиуд үнэгүй, гэж хэлэхэд таатай байна.

Хэрэв миний хүүхэд

сургуульд явах боломжтой

болгохын тулд би юу хийх

ёстой вэ?

Та хүүхдийнхээ явахыг хүссэн сургуультай холбоо барь. Та тэдэнтэй холбоо барих үедээ, танд сургуульд явах хүсэлтэй хүүхэд байгаа бөгөөд захиралтай ярихыг хүсэж байгаа хэл. Сургууль нь цагаачлалын алба болон цагдаагаас бие даасан гэдгийг мэдэхэд таатай байна. Та хүүхдийнхээ сургуулийн ажилтантай холбоо барихдаа нууцлаг нэгэн байж болно. Та зөвхөн хүссэн үедээ л өөрийн мэдээллийг өгч болно.

Сургуулийн ажилтны

анхааралд:

Холбоо барих мэдээлэл: Маш олон бичиг баримтгүй цагаачид тогтсон хаяггүй байдаг учир, хүүхдүүд болон тэдний эцэг эхтэй холбоо барих хамгийн хялбар арга нь утсаар ярих юм.

Дугаар: Зарим бичиг баримтгүй цагаачидын бичиг баримт дутуу байж магадгүй.

Нууцлал болон хамгаалалт: Бичиг баримтгүй цагаачдын хүүхдүүдийн болон насанд хүрэгчдийг хамгаалахын тулд, бичиг баримтгүй цагаачдын нөхцөл байдал болон мэдээллийг нууц байлгах хэрэгтэй. Зөвхөн хэлж болох хүнд л өгөх хэрэгтэй.

Хуулийн дагуу боловсрол

тэгш эрхтэй

(Хууль нь бичиг баримтгүй цагаачдын хүүхдүүд сурах эрхтэй болсон)

2013 оны 7 сарын 1 нээс, Шведэд байгаа бүх хүүхдүүд сурах адилхан эрхтэй болсон. Энэ нь (Bill 2012/13: 58) Боловсролын хууль (2010:800) өөрчлөлтийн дагуу болсон, иймээс зөвшөөрөлгүй байгаа хүүхдүүдэд, тэтгэмж олгоно, урьдчилсан-сургууль, дунд сургууль болон түүнтэй адилтгах сургуулиуд болон ахлах сургууль болон тусгай ахлах сургуулиудад адил эрх эдлэнэ. Эдгээр хүүхдүүд нь сургуулийн унаанд суух эрхтэй.

Ямар нэг асуулт

байна уу?

Бичиг баримтгүй цагаачид Улаан Загалмайн Хурлын газартай холбоо барих:

Э-шуудан:

motesplats@redcross.se

Энэ мэдээлэл нь Англи хэл дээр бас байгаа.

Энэ мэдээлэл нь Араб хэл дээр бас байгаа.

Энэ мэдээлэл нь Монгол хэл дээр бас байгаа.

Энэ мэдээлэл нь Перс хэл дээр бас байгаа.

Энэ мэдээлэл нь Орос хэл дээр бас байгаа.

Энэ мэдээлэл нь Испани хэл дээр бас байгаа.

Энэ мэдээлэл нь Серби-хорват хэл дээр бас байгаа. Энэ мэдээлэл нь Албани хэл дээр бас байгаа.